

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/62/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: У.Ербол Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа	14
4.2 Төлбөрийн акт	14
4.3 Албан шаардлага	14
4.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	38,801,729.74	28,708,328.64
33	АВЛАГА	5,396,371.00	558,177.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,396,371.00	558,177.00
35	БАРАА МАТЕРИАЛ	33,405,358.74	28,150,151.64
354	Хангамжийн материал	33,405,358.74	28,150,151.64
35410	Бичиг хэргийн материал	330,200.00	247,650.00
35420	Аж ахуйн материал	5,119,676.00	4,507,095.00
35440	Түлш, шатах тослох материал	10,148,009.99	8,137,209.99
35460	Хүнсний материал	7,953,184.75	5,403,908.65
35470	Бусад хангамжийн материал	9,854,288.00	9,854,288.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	333,606,492.06	346,719,532.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	333,606,492.06	346,719,532.32
392	Биет хөрөнгө	293,078,492.06	306,323,532.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	286,206,428.00	286,206,428.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(13,251,761.04)	(28,007,641.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	18,424,253.00	17,605,281.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,269,622.68)	(14,269,785.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,713,273.00	28,431,692.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,833,107.22)	(13,570,127.76)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,303,507.00	17,974,146.81
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,303,507.00)	(1,771,989.18)
39217	Ном	13,089,029.00	13,725,529.00
393	Биет бус хөрөнгө	40,528,000.00	40,396,000.00
39301	Програм хангамж	660,000.00	660,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(132,000.00)	(264,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	40,000,000.00	40,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	372,408,221.80	375,427,860.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	98,420.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	98,420.00	-
413	Өглөг	98,420.00	-
4136	Бусад өглөг	98,420.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	98,420.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	372,309,801.80	375,427,860.96
51	Засгийн газрын хувь оролцоо	372,309,801.80	375,427,860.96
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	92,947,458.00	92,947,458.00
51101	Өмч: - төрийн	92,947,458.00	92,947,458.00
512	Хуримтлагдсан үр дүн	198,138,444.18	201,256,503.34
51210	Өмнөх үеийн үр дүн	198,138,444.18	198,138,444.18
51220	Тайлант үеийн үр дүн		3,118,059.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	81,223,899.62	81,223,899.62
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	372,408,221.80	375,427,860.96

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	500,471,396.00	275,935,905.81
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	513,440.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	513,440.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	513,440.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	513,440.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	499,957,956.00	275,935,905.81
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	487,366,956.00	232,703,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	251,016,656.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	236,350,300.00	232,703,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,468,680.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,468,680.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	12,591,000.00	38,764,225.81
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага /	12,591,000.00	11,315,000.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага /		27,449,225.81
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	252,765,738.05	272,817,846.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	252,765,738.05	272,817,846.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	240,367,538.05	265,136,291.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,973,641.00	188,457,994.00
210101	Үндсэн цалин	165,766,685.00	174,777,994.00
210104	Урамшуулал	12,206,956.00	9,142,200.00
210105	Гэрээт ажлын хөлс		4,537,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,195,500.00	24,518,700.00
210201	Тэтгэврийн даатгал	22,097,600.00	17,253,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,894,800.00	1,816,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,390,400.00	1,453,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	346,600.00	363,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,466,100.00	3,632,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,577,231.01	11,727,380.00
210301	Гэрэл, цахилгаан	640,420.00	789,580.00
210302	Түлш, халаалт	7,936,811.01	10,937,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,270,110.00	5,297,281.00
210401	Бичиг хэрэг	332,920.00	44,450.00
210402	Тээвэр, шатахуун	2,331,200.00	2,913,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	480,000.00	706,500.00
210404	Ном, хэвлэл		25,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,125,990.00	1,447,031.00
2105	Нормативт зардал	9,569,572.20	12,629,601.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,300.00	95,700.00
210502	Хоол, хүнс	8,425,022.20	11,425,951.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,069,250.00	1,107,950.00

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	500,000.00
210604	Урсгал засвар	-	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	342,500.00	101,900.00
210702	Дотоод албан томилолт	342,500.00	101,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	343,800.00	442,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,300.00	130,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	312,500.00	312,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,095,183.84	21,460,935.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	265,000.00	3,818,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,830,183.84	17,642,685.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,398,200.00	7,681,555.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,282,900.00	6,662,550.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,282,900.00	6,662,550.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,115,300.00	1,019,005.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,115,300.00	1,019,005.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	247,705,657.95	3,118,059.16
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	247,705,657.95	3,118,059.16

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00		0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,947,458.00	81,223,899.62	198,138,444.18		372,309,801.80
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,947,458.00	81,223,899.62	198,138,444.18		372,309,801.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	92,947,458.00	81,223,899.62	198,138,444.18		372,309,801.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			3,118,059.16		3,118,059.16
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	92,947,458.00	81,223,899.62	201,256,503.34		375,427,860.96

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	248,941,300.00	248,486,680.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	248,941,300.00	248,486,680.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	236,350,300.00	232,703,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	236,350,300.00	232,703,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,468,680.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,468,680.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	12,591,000.00	11,315,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12,591,000.00	11,315,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	248,796,300.00	245,180,180.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	248,796,300.00	245,180,180.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	236,005,100.00	238,028,775.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	179,516,900.00	183,619,800.00
210101	Үндсэн цалин	164,244,500.00	169,939,800.00
210104	Урамшуулал	15,272,400.00	9,142,200.00
210105	Гэрээт ажлын хөлс		4,537,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,195,500.00	24,518,700.00
210201	Тэтгэврийн даатгал	22,263,600.00	17,253,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,732,800.00	1,816,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,386,400.00	1,453,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	346,600.00	363,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,466,100.00	3,632,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,591,000.00	10,815,000.00
210301	Гэрэл, цахилгаан	888,000.00	888,000.00
210302	Түлш, халаалт	10,703,000.00	8,927,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,756,500.00	4,272,000.00
210401	Бичиг хэрэг	251,200.00	44,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,331,200.00	2,913,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	570,000.00	706,500.00
210404	Ном, хэвлэл	-	25,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	604,100.00	421,700.00
2105	Нормативт зардал	9,345,300.00	10,025,675.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	75,300.00	95,700.00
210502	Хоол, хүнс	8,334,000.00	9,316,175.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	936,000.00	613,800.00

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хөгшил, урсгал засварын зардал	-	500,000.00
210604	Урсгал засвар	-	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	342,500.00	101,900.00
210702	Дотоод албан томилолт	342,500.00	101,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	343,800.00	439,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,300.00	127,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	312,500.00	312,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	913,600.00	3,735,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	913,600.00	3,735,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,791,200.00	7,151,405.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,675,900.00	6,132,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,675,900.00	6,132,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,115,300.00	1,019,005.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,115,300.00	1,019,005.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	145,000.00	3,306,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	145,000.00	3,306,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	145,000.00	3,306,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	145,000.00	3,306,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	145,000.00	3,306,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(145,000.00)	(3,306,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	244,018,000.00	243,007,675.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	244,018,000.00	243,007,675.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	237,864,500.00	236,875,275.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	183,619,800.00	183,619,800.00
210101	Үндсэн цалин	169,939,800.00	169,939,800.00
210104	Урамшуулал	9,142,200.00	9,142,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,537,800.00	4,537,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,518,700.00	24,518,700.00
210201	Тэтгэврийн даатгал	17,253,900.00	17,253,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,816,200.00	1,816,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,453,000.00	1,453,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	363,200.00	363,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,632,400.00	3,632,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,815,000.00	10,815,000.00
210301	Гэрэл, цахилгаан	888,000.00	888,000.00
210302	Түлш, халаалт	8,927,000.00	8,927,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,258,600.00	4,258,600.00
210401	Бичиг хэрэг	89,200.00	89,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,913,800.00	2,913,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	706,500.00	706,500.00
210404	Ном, хэвлэл	127,400.00	127,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	421,700.00	421,700.00
2105	Нормативт зардал	10,927,400.00	10,025,675.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	95,700.00	95,700.00
210502	Хоол, хүнс	10,217,900.00	9,316,175.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	613,800.00	613,800.00

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	101,900.00	101,900.00
210702	Дотоод албан томилолт	101,900.00	101,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур	527,400.00	439,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	127,400.00	127,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	312,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,595,700.00	2,595,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,595,700.00	2,595,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,153,500.00	6,132,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,153,500.00	6,132,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,153,500.00	6,132,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	244,018,000.00	243,007,675.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	232,703,000.00	231,692,675.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлэгээс санхүүжих	232,703,000.00	231,692,675.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,315,000.00	11,315,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	11,315,000.00	11,315,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	16.00	18.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	6.00	6.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00
620004	Гэрээт ажилтан	1.00	3.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	16.00	18.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	8.00	8.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	10.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,460,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,460,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,460,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	160,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	160,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,300,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,468,680.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,468,680.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,468,680.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор У.Ербол гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Б/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1404.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 2.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3.0 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	5396.40	558.20	-4838.2
Урьдчилгаа	0.00	0.00	0.0
Бараа материал	33405.4	28150.2	-5255.2
Үндсэн хөрөнгө	333606.5	346719.5	13113.0
Нийт хөрөнгө	372408.2	375427.8	3019.6
Өр төлбөр	98.4	0	-98.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	372309.8	375427.8	3118.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	372408.2	375427.8	3019.6

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 0.5 сая төгрөг болж 4.8 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны нийгмийн даатгалын шимэтгэлийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 28.2 сая төгрөг болж 5.2 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 28.6 сая төгрөгийн бараа материал худалдан авч үйл ажиллагаандаа 33.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 346.7 сая төгрөг болж 13.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд аймгийн ОНХС-аас хийлгэсэн 10.0 сая төгрөгийн гүний худаг, 3.9 сая төгрөгийн гэрэлтүүлэг, БШУЯ-наас нийлүүлсэн 2.4 сая төгрөгийн схем тоглоом, хувь хүмүүсийн хандиваар бэлтгэсэн 3.5 сая төгрөгийн кабинет тохижуулалт, “Алтай институт” ОУБ-аас хандивласан 7.5 сая төгрөгийн хүүхдийн ор, нийт 27.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3.3 сая төгрөгийн хөрөнгийг орлого авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 133 дугаар тогтоол, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 48 дугаар тогтоолоор акталсан байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 92.2 сая төгрөгийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 375.4 сая төгрөг болж 3.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 275.9 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 224.6 сая төгрөгөөр буюу 44.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хөрөнгийн санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 20.0 сая төгрөгөөр буюу 7.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлууд байна. Цалингийн зардал, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос нэмэгдэж, албан томилолтын зардал өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны анх батлагдсан төсөв 245.4 сая төгрөг, тодотгосон төсөв 244.0 сая төгрөг байна. Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 1.4 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд:

Цалингийн зардлыг 20.1 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2.4 сая төгрөгөөр нэмэгдэж, хоол, хүнсний зардлыг 23.0 сая, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлаас 2.5 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Цалингийн зардлыг 22.5 сая төгрөгөөр нэмсэн нь 2 орон тоо илүү байгаатай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 244.0 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 243.0 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг нийт дүнгээр 1.0 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Энэ нь хоол, хүнс, аудит баталгаажуулалт, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал зардлын хэмнэлт байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Дээд шатны төсвийн захирагчаас “Шинэ үе сургалт” төслөөр 4.4 сая төгрөгийн санхүүжилт авч хичээл үйлдвэрлэлийн дадлага хийхэд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Нийт санхүүжилт 244.0 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай 194.4 сая төгрөгийн зардлыг хасахад 49.6 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 4.9 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байна.

Тус сургуулийн төсвийг тодотголоор 1.4 сая төгрөгөөр танаж, оны эцэст 1.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж нийт 2.4 сая төгрөгийн төсвийн хэмнэлт гаргаж, тогтоолын 1.4-д заасныг зөрчиж 775.0 мянган төгрөгийн тавилга худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй гэж үзэх үндэстэй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2021 онд нийт 275.9 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 275.9 сая төгрөгийн 132 мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулж, 17 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалингийн зардлын төсвөөс зарцуулагдаагүй 5.4 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэхгүйгээр нийгмийн даатгалын шимтгэл, татварын тооцооноос илүү шилжүүлж авлага үүсгэсэн зөрчилд албан шаардлага, сургуулийн дотуур байрны хоол, хүнсэнд хэрэглэх махыг их хэмжээгээр нөөцөлж, үлдэгдэл махыг зарцуулж дуусаагүй байхад их хэмжээгээр мах худалдан авсан нь чанар байдал алдагдах эрсдэлтэй, Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6.3 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй зөрчилд зөвлөмж өгөгдсөн бөгөөд хэрэгжилтийг давтан шалгахад хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 171.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 157.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 14.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй.

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 157.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн дансанд 118.4 сая төгрөгийн, бараа материалын дансанд 14.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэж тайлагнасан боловч жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хөрөнгийн нэг бүрийн үнэ, нийт дүнгээр гаргаагүй, дутуу тоолсон, тооллогын бүртгэлийн дүнг санхүүгийн тайлангийн дахь үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулах боломжгүй,

2. Хандиваар хүлээн авч бүртгэсэн 15.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн баримтын бүрдэл дутуу, нярвын бараа материалын бүртгэл хөтлөлт хангалтгүй, хоол хүнсний зарцуулалтын тайлан, нягтлан бодогчийн гаргасан бараа материалын тайлангаас 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй, 0.3 сая төгрөгийн нормын хувцас, 0.6 сая төгрөгийн принтерийг орлого аваагүй, тээвэр шатахуунд зарцуулсан 2.9 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэж тайлагнасан, шатахууны зарцуулалтын жагсаалтад хэрэглэсэн албан тушаалтнуудаар гарын үсэг зуруулж баримтжуулаагүй, шуудан холбооны зардлын 0.7 сая төгрөгийг бүрдэл дутуу баримтаар шилжүүлсэн нь

Энэ нь Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.5, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.1, 20 дугаар зүйлийн 20.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2-ийн 1,2, 71 дүгээр зүйлийн 1-ийн 2, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 49.6 сая төгрөгийн төсвийн 10 хувь 4.9 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, 2472.4 мянган төгрөгийн урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, тогтоолын 1.4-д заасныг зөрчиж 0.7 сая төгрөгийн тавилга худалдан авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-т ” үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.4-т ” энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга,-ийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Акталсан хөрөнгийн данснаас хасах, устгалт тайлагналтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Баян-Өлгий аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 133 дугаар тогтоол, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 48 дугаар тогтоолоор 14.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах тухай зөвшөөрөл олгосон боловч Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж, дүгнэлт гаргуулаагүй, байгууллагын даргын шийдвэрээр акталж, устгал хийгээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг хэрэгжүүлэн ажиллах

2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Шилэн дансанд тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.5, 6.1.6 дах заалтуудыг мөрдөж мэдээллийг хугацаанд бүрэн байршуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дэлүүн сумын ЕБ-ын 2-р сургууль	4	171.5					2	157.0	2	14.5